

ТӨГС ЭЗЭМШИХ СУРГААЛЫН ТОЙМ



ТӨГС ЭЗЭМШИХ СУРГААЛЫН ЗОРИЛГО

Төгс эзэмших сургаалын зорилго нь суралцагчдад Есүс Христ болон Түүний сургаал дээр сууриа тавихад туслах явдал юм. Төгс эзэмших сургаал хөтөлбөр нь сүнслэг мэдлэг олж авах, Есүс Христийн сайн мэдээний сургаалыг төгс эзэмших гэсэн нэмэлт хоёр үр дүн дээр төвлөрдөг.

ТӨГС ЭЗЭМШИХ СУРГААЛЫН ҮР ДҮН

- Сүнслэг мэдлэг олж авах нь
 - *Итгэлээр үйлдэх*: Бурханд итгэж, юуны түрүүнд үнэн гэдгийг нь аль хэдийн мэддэг зүйлдээ найдан, чин сэтгэлээсээ залбирч, суралцаж, Түүнд хандах мөн хариултуудыг үргэлжлүүлэн эрэлхийлэх.
 - *Мөнхийн талаас нь харах үзэл баримтлал*: Сургаалын утга санаа, асуулт, нийгмийн асуудал, түүхэн үйл явдлыг авралын төлөвлөгөө, Аврагчийн сургаалын хам сэдэв дотор авч үзэх.
 - *Тэнгэрээс томилогдсон эх сурвалжууд*: Ариун Сүнс, судрууд болон бошиглогчид мөн эцэг эх, Сүмийн удирдагчид болон бусад найдвартай эх сурвалжаар дамжуулан илүү гүн ойлголтыг эрэлхийлж, сүнслэг мэдлэг олж авах.
- Сургаалыг төгс эзэмших нь
 - *Сургаалын сэдэв ба түлхүүр мэдэгдлүүд*: Сургаалын 9 сэдвийн талаар илүү гүнзгий ойлголтыг хөгжүүлэх. “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсэгт болон сургаалын есөн сэдэв тус бүрд тодорхойлсон сургаалын түлхүүр мэдэгдлүүдийг ойлгох.
 - *Судрын хэсгүүд*: Сургаалын түлхүүр мэдэгдлүүд төгс эзэмших сургаалын хэсгүүдэд хэрхэн заагддагийг мэдэж авах, тэдгээр хэсгийг санах, байгаа газрыг нь олж сурах.
 - *Сургаалыг тайлбарлаж, хэрэгжүүлэх*: Сургаалын түлхүүр мэдэгдэл бүрийг холбогдох төгс эзэмших сургаалын хэсгүүдийг ашиглан тодорхой тайлбарлах. Есүс Христийн сайн мэдээний сургаалыг өдөр тутам сонголт хийхдээ мөн сургаал, нийгэм, түүхтэй холбоотой асуудал, асуултуудад хариулахдаа ашиглах.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг doctrinalmastery.lds.org-оос авч болно.